



*Зорилго: Хүртээмжтэй даатгалын салбарын гол оролцогчдын манлайлал, шинэ санал, санаачлага гаргах чадварыг хөгжүүлэх болон даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх боломжит шинэчлэл, өөрчлөлтийг бий болгох*

ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/, Дэлхийн манлайллын академи /GLA/ болон Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэгч Олон Улсын байгууллага /A2I/ хамтран 2017 оны 11 дүгээр сараас эхлэн “Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх хөтөлбөр”-г Кени, Албани, Гана, Монгол зэрэг 4 оронд хэрэгжүүлж байна.



Хөтөлбөрийн хүрээнд Үндэсний багууд хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх, зохистой зохицуулалтын орчныг бий болгох талаар шинэ санаа, санаачлагыг гаргах юм. Манай улсын үндэсний багт Санхүүгийн зохицуулах хороо тэргүүтэй Монголын даатгагчдын холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбоо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим болон даатгалын компанийн төлөөллүүд багтаж байгаа.

12 сарын хугацаанд хэрэгжих “Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх төсөл”-өөр даатгалын салбарын өнөөгийн нөхцөл байдал, хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг үнэлж дүгнэлт гарган, цаашид хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх боломжууд, авч хэрэгжүүлэх шинэлэг арга хэрэгслүүдийг судлан ажиллаж байна.

Хөтөлбөр нь даатгалын салбарын тал бүрийн оролцогчид нэгдэн даатгалыг хэрэгцээтэй хүмүүст хүргэхэд чиглэсэн шинэлэг шийдлийг боловсруулж, туршиж үзэх боломжийг олгоно. Төслийн хүрээнд оролцогч улсууд үндэсний хэмжээний болон оролцогч улс хоорондын семинар хэлэлцүүлгүүдийг өрнүүлдэг.

Төсөл хэрэгжиж дууссаны дараа хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнийг хүртээмжтэй болгох, шинэлэг шийдлүүд дээр суурилсан түгээлтийн сувгийг нээх, нэгдсэн даатгалыг бий болгоход чиглэсэн төрийн зохицуулалтыг сайжруулах зэрэг өргөн хүрээтэй асуудлуудыг тусгасан Монгол улсын Хүртээмжтэй даатгалын нэгдсэн стратеги төлөвлөгөө баримт бичиг бий болох юм.